



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар A/15

Баян-Овоо

**Ажлын хэсэг байгуулах
тухай**

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.8 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх заалт, 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалт, 72.3 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 439 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2016 оны 126 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Сургуулийн 2025 оны 04 дүгээр сарын 15-наас дотуур байрны багшийн ажлыг хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Эрдэнэцэцэг	(Сургалтын менежер)
Нарийн бичгийн дарга:	Х.Цолмончимэг	(Номын санч)
Гишүүд:	Ж.Мягмартуяа	(Архив, бичиг хэрэг)

2. Дотуур байрны эд хогшил, бараа материалыг 2025 оны 04 дүгээр сарын 15-наас 04 дүгээр сарын 25-ны хооронд нэг бүрчлэн тоолж бүртгэхийг комисст үүрэг болгосугай.

3. Тооллогын бүртгэлийг сайтар хангаж, комиссыг холбогдох мэдээллээр шуурхай хангаж ажиллахыг нягтлан бодогч (Э.Дэнсмаа)-д даалгасугай.

**ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Д.ЭРДЭНЭТУЯА